

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№ 16/438

ШУС, НУС

2015

**“АРДЧИЛАЛ” СОНИН ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛИЙН ТОГТОЛЦОО**  
**БҮРЭЛДЭХЭД ХАМГИЙН ИХЭЭР НӨЛӨӨЛСӨН ХЭВЛЭЛ БОЛОХ НЬ**

Б.Галаарид\*

\* Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн Ерөнхийлөгч, докторант

**Түлхүүр үг:** чөлөөт хэвлэл, ардчилал, ардчилсан хөдөлгөөн, “Ардчилал” сонин, “Сайн байна уу?” сонин

**1990** он бол Монголын тогтмол хэвлэлийн түүхэнд алтан үсгээр бичигдэх онцгой жил юм. Монголын нийгмийг бүхэлд нь доргиосон ардчиллын анхдагч 13-ын 5 нь сэтгүүлч байв. Үүнийг тухайн үед нийгмийг сэтгүүлчид хамгийн ихээр доргиосон гэж үзэж болно. Тэгвэл ардчиллын давалгаан эргээд сэтгүүл зүйг хамгийн ихээр өөрчилсөн байна. Тэрхүү өөрчлөлтийн эхлэл, шинэ сэтгүүл зүйн анхдагч нь “Шинэ толь” сонин юм.

Монголын ардчилсан холбооны анхдагчдын нэг С.Амарсанаа “Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд” номдоо бичсэнээс үзвэл 1990 оны 1 дүгээр сарын 6-ны бямба гарагт МУИС-ийн криминалистикийн лабораторид болсон МоАХ-ны Ерөнхий зохицуулах зөвлөлийн гишүүдийн ээлжит уулзалтын үеэр МоАХ өөрийн сонин хэвлэлтэй болох асуудал яригдаж сонин, сэтгүүлийнхээ нэрийг тогтсон байна. Тэрбээр «Сонинтой болох тухай асуудлыг хэлэлцэхэд нэг сэтгүүл, нэг

сонинтой больё гэсэн санал гарлаа. Би сониноо “Шинэ үе” гэж нэрлэх санал гаргав. Тэгтэл Дарь. Сүхбаатар “Цагийн толь” гэж нэрлэх санал гаргав. Улсын багшийн дээд сургууль дээр Дарь. Сүхбаатар бичгийн цаас нийлүүлж үдээд ийм нэртэй оюутны чөлөөт сонин гаргаж байжээ. Зөвлөлтөд “диссидент” гэх тэрсүү үзэлтнүүд нь ийм маягаар нийгмээ шүүмжилсэн өгүүлэл, ном зохиол хэвлэн тараадаг, түүнийг нь “самиздат” (өөрсдөө хэвлэсэн) гэж нэрлэдэг байсан нь санаанд оров. Гурван дугаар гаргасны дараа НАХЯ хаасан гэнэ. Ингээд хэсэг ярилцаж зөвлөлдсөний дараа “Шинэ үе”-ийн эхний үгийг, “Цагийн толь”-ийн сүүлийн үгийг авч нийлүүлээд “Шинэ толь” гэж нэрлэхээр шийдлээ гэж дурссан байна<sup>1</sup>. «Ардчилсан үйл явцын эхэн үе дэх анхны сонин бол 1990 оны 3 дугаар сараас эхэлсэн Шинэ толь юм. 1988 оны мөнөөх хаагддаг “Цагийн толь”-иос “толь”-ийг нь аваад, С.Цогтсайхан нарын 1989 оны 1 дүгээр сард гудамжинд наасан ухуулах хуудасныхаа доор бичсэн “Шинэ үе” гэдэг үгээс “Шинэ”-ийг аваад сэтгүүлч С.Амарсанаа бид хоёрын өгсөн нэр юм шүү дээ. Эрхлэгчээр нь С.Баяр (С.Зоригийн ах) ажиллаж байсан»<sup>2</sup> гэж 1989 онд Монголд өрнөсөн ардчилсан хөдөлгөө-

нийг үүсгэн санаачлагчдын нэг Дарь. Сүхбаатар 2013 оны 1 дүгээр сарын 22-нд үүнийг бичигчид илгээсэн цахим захидалдаа бичсэн нь С.Амарсанаагийн бичсэнтэй яв цав таарч байна. Гэхдээ “Шинэ толь”-ийн анхны дугаар 2 дугаар сарын 18-нд Монголын Ардчилсан Холбооны анхдугаар их хурал дээр тарсныг Дарь. Сүхбаатар 3 дугаар сар гэж андуурсан бололтой. Ардчилсан хөдөлгөөнд идэвхтэй оролцож явсан хүмүүсийн дурсамжинд энэ мэтээр өдөр цаг, үйл явдлыг андуурах явдал мэр сэр гэлтгүй гарч байгааг судлаачид анзаарч, амьд гэрч, оролцогчдын дурсамж яриаг ч гэсэн аль болох нарийн нягтлах шаардлага гарч байна.

Тухайлбал, «Энэ өдөр (1990 оны 2 дугаар сарын 18-ны ням гараг — Б. Г.) мөн Монголын анхны чөлөөт хэвлэл “Шинэ толь” сонины анхны дугаарыг нууцаар хэвлэн гаргасан юм. Уг дугаарыг би редакторлаж, Мягмарсамбуу макетыг нь хийгээд хэвлүүлэх ажиллагааг Зориг өөрөө биечлэн хариуцсан билээ»<sup>3</sup> гэж С.Амарсанаа бичсэн нь “Шинэ толь”-ийг “Ардчилал” сонинтой эндүүрсэн хэрэг бололтой.

Энд нэр дурдагдаж буй Ш.Мягмарсамбуу болохоор “Тэр сониныг Шинжлэх ухаан мэдээллийн төвд ажиллаж байсан Тэрбиш, Эрдэнэбат зэрэг гурван залуугаар хийлгэсэн юм байна лээ”<sup>4</sup> гэж хэлсэн нь тухайн цаг үеийн үйл явдалд оролцож байсан олон хүний яриатай таарч байна. Ш.Мягмарсамбуу “Шинэ толь” сонины анхны дугаарын дэглэлтийг хийгээгүй, тэр үед “Ардчилал” сонины олон нүүр бүхий дугаар бэлтгэх даалгавар С.Зоригоос аваад завгүй байсан нь өөрийнх нь яриа дурсамжаар батлагдаж байна<sup>5</sup>.

«Хурал эхлэхэд л ардчиллын дуу хоолой болсон “Шинэ толь” сонины

эхний дугаар тараагдаж билээ. Энэ сониныг миний дүү Отгонбаярын минь дотнын найз Нацагийн Жаргалсайхан макет загварыг хийгээд хэсэг нөхдийн хамт 17-ны шөнө хэвлүүлэн авчирч хурлын төлөөлөгчдийн сандал дээр тавьж байсныг сайн мэдэх юм»<sup>6</sup> гэж Ардчилсан хөдөлгөөний идэвхтэй тэмцэгчийн нэг, “Дугуй заалны Оюунаа” гэгддэг Тодын Оюунчимэг дурсамжийн номдоо бичсэн байна. Энд яригдаж буй Н.Жаргалсайхан бол мөнөөх Шинжлэх ухаан, мэдээллийн төвд ажиллаж байсан гурван залуугийн нэг байж мэдэхээр байна.

“Шинэ толь” сонин А3 форматын хоёр нүүрээр нийтдээ гучаад дугаар гараад үйл ажиллагаагаа зогсоожээ.

**А**ливаа хэвлэл мэдээллийн хэрэгслийг МАХН-аас, коммунист үзэл суртлаас хамааралгүйгээр тогтмол эрхлэн гаргаж болно гэдгийг нотлон харуулсан сонин бол “Ардчилал” юм. “Ардчилал” сонины анхны албан ёсны дугаар 1990 оны 4 дүгээр сарын 6-7-нд шилжих шөнө Улсын хэвлэлийн комбинатын Сонины хэвлэх үйлдвэрт А2 форматын 4 нүүрээр хэвлэгджээ.

Хэдийгээр анхны болоод дараа дараагийн дугааруудын алинд нь ч сониныхоо бодлого, зорилго, редакцийн байр суурийг тодорхойлсон ямар нэгэн өгүүлэл нийтлээгүй ч үзэл бодлын чөлөөт индэр байх, өөрөөр хэлбэл чөлөөт хэвлэл байх эрмэлзэлтэй байсан нь «“Ардчилал” сонин МоАХ, МоАН-ын үзэл санааг түгээхээс гадна сэтгүүлчид, сэхээтнүүд үгээ зоригтой хэлэхэд зориулагдсан чөлөөт индэр болох учиртай. Сайн хэлж, уриалж, ухуулахгүй бол сэтгүүлчид маань шинэ үзэл санааг идэвхтэй дэмжихэд төдийлөн бэлэн биш байна»<sup>7</sup> гэж тус сониныг анх гардан хариуцаж

байсан хүмүүсийн нэг С.Амарсанаа 1990 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн тэмдэглэлдээ бичсэнээс тодорхой ойлгогдож байна. Мөн ардчиллын үйл хэргийн төлөө ил тод ажиллах иргэний зоригтой сэтгүүлч тухайн үед цөөн байсан учраас сонин гаргахад хүч дутмаг байсныг энэ тэмдэглэл харуулж байна.

Сонин хэвлэх асуудал 1990 оны эхнээс яригдсан, МоАХ-ны ерөнхий зохицуулагч С.Зориг өөрийн төрсөн ах, “Новости Монголии” сонинд ажиллаж байсан С.Баяр, мөн сонины ажилтан Ш.Мягмарсамбуу нарт “Ардчилал” сонины анхны дугаарыг эрхлэн гаргах үүрэг өгсөн боловч боловч боловсон хүчин дутагдалтайн улмаас сонины редакци бүрдээгүй нь “Хоёрхон хүнээс чинь яаж ч өөдтэй сайн сонин гарах вэ дээ. Тэд нар материал өгнө гэсэн боловч байдаггүй. Тэр үед Ардчилсан холбооны зохицуулах зөвлөл хуралдав. Хуралд нь бид сониноо редакцийн бүтэцтэй болгож зохион байгуулаач гэж хүсэлт гаргав”<sup>8</sup> гэж “Ардчилал” сонины анхны макетыг хийсэн Ш.Мягмарсамбуу дурссан, анхны эрхлэгч С.Амарсанаа «Бүгд цаанаа үндсэн ажилтай учраас редакци байхгүй, эрхлэн гаргах мэргэжлийн хүнгүй яваад байсан аж. Мягмарсамбуу сүүлийн хоёр удаагийн ЕЗЗ-ийн хуралд оролцож “Сониноо гаргах гэж байна. Хүн нэмж өгөөч” гэж нэхдэг байв»<sup>9</sup> гэж бичсэнээс үзэхэд тодорхой байна.

Сэтгүүлч С.Амарсанаа “Хөдөлмөр” сониноос 1990 оны 3, 4 дүгээр сарын заагаар халагдаж, улмаар С.Баяр, Ш.Мягмарсамбуу нарт хүч хавсрахаар ирснээр “Ардчилал” сонины редакци бий болжээ. Шинэ сонины эхийг “Новости Монголии” сонины газарт бэлтгэн бэлэн болсон материалуудаа Сонины хэвлэх үйлдвэрийн ажилчин

Л.Азбаярт аваачиж өгдөг байжээ. Ш.Мягмарсамбуугийн төлөвлөсөн макетын дагуу сонины үйлдвэрийн ажилчид өрж боож, дардас уншилтыг С.Амарсанаа, Ш.Мягмарсамбуу, С.Баяр нар хийж, сэтгүүлч Цахиагийн Элбэгдорж, Батын Эрдэнэбаатар нар тэдэнд туслан зарим материалыг эхтэй нь тулгалцан уншсан байна. Энд онцлоход МоАХ-г үүсгэн байгуулагчдын нэг сэтгүүлч Ц.Элбэгдорж “Ардчилал” сонины энэхүү албан ёсны анхны дугаар, мөн Эрдэнэтэд хэвлэгдээд сүүлд нь хураагдсан анхны дугаар хоёрын аль алиных нь эх материалыг уншилцаж гар бие оролцсон бол анхны дугаарын макетыг хийсэн Ш.Мягмарсамбуу дараахан нь гарсан “Үндэсний дэвшил” сонины эх загварыг мөн гаргаж өгч байсан нь тухайн үед ардчиллын үйл хэрэгт ил тод оролцох сэтгүүлч цөөхөн, байгаа хэд нь чин сэтгэлээрээ энд тэндгүй очиж хүч нэмж, чөлөөт хэвлэлийн эх суурийг тавихын төлөө зүтгэж байсантай холбоотой юм.

**С**үхбаатарын талбайд улс төрийн өлсгөлөн анх зарласан 13 хүний нэг З.Эрдэнэбат анхны чөлөөт хэвлэлүүд бий болохоор дуншиж байсан цаг үеийн тухай дурсамждаа «МоАХ-ны Ерөнхий Зохицуулах Зөвлөлд байхдаа одоогийн Ерөнхийлөгч Элбэгдорж бид хоёр “Ардчилал” сонины материалаа унших, цэгцлэх подвал хайгаад гутлынхаа улыг цоортол алхаж байж билээ. Бас С.Амарсанаа бид хоёр хэвлэх үйлдвэрт партизаны аргаар сониныхоо ганц дугаарыг ч гэсэн гаргачих гэж зүтгээд ердөө ч бүтээгүй юмдаг. Ардчилсан нам байгуулагдаж байж л бид сая нэг юм хууль ёсоор “Ардчилал” сонины анхны дугаарыг гаргаж чадаж билээ»<sup>10</sup> гэж бичсэн нь тэр үед шинээр сонин

хэвлүүлэх гэдэг амаргүй ажил байсныг нотолж байна.

“Ардчилал” сонины анхны дугаарын загвар дэглэлтийг Ш.Мягмарсамбуу шинэлэг байдлаар хийж, тухайн үедээ манай сэтгүүл зүйд төдийлөн нэвтрээгүй байсан задгай макет ашиглаж, нэгдүгээр нүүрний гол зураг болох жагсаал цуглааны зургийг нүүрний хэмжээний өргөнтэйгээр тавьж, “Шинэ цаг ирлээ, сэргээе!” гэсэн гарчгийг мөн томоор өгсөн нь тухайн үедээ дизайны зоримог шийдэл, шинэ өнгө төрх болж чаджээ. Ингэхдээ МОАХ-ны логон дээрх гал, “Шинэ цаг ирлээ, сэргээе!” гэсэн гарчгийг улаан өнгөөр ялгаж, бусдыг нь хар цагаанаар хэвлэсэн байна.

Сонины нэгдүгээр нүүрийн доод хэсэгт МоАХ-ны ерөнхий зохицуулах зөвлөлийн гишүүн Д.Дорлигжавын “Улс нийгмийнхээ сайн сайхны төлөө” гарчигтай өгүүлэл, мөн “Хоёр захидал” гарчгийн дор малчдаас ирүүлсэн захидал нийтэлсэн байна.

Энэ дугаарт “Цаг үеийн улс төрийн байдалд МАН-ын хийх дүгнэлт” албан материал, С.Амарсанаагийн “Нэр төрийн хэрэг”, “Ардчилсан сонгууль” өгүүлэл, М.Энхээгийн “Өлсгөлөн” гэсэн гарчигтай ярилцлага, П.Нэргүйн “Нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудал”, Г.Бошигтын “Хуран цуглахын цаана...” өгүүлэл, мөн 1989 оны 12 дугаар сарын 10-наас 1990 оны 3 дугаар сарын 11 хүртэлх 90 хоногийн хугацаанд улс оронд болж өнгөрсөн үйл явдлыг “Гурван сар” нэрийн дор тоймлосон бүтэн нүүр багтжээ. Сониныг эрхлэн гаргагч, редакцийн талаар “Сонины зөвлөл” гэж бичсэнээс өөр тодорхой мэдээлэл байхгүй ч анхны дугаарыг бүтээхэд оролцсон Л.Азбаяр, С.Амарсанаа, С.Баяраа, Ш.Мягмарсамбуу, Ц.Элбэг-

дорж нарын 28 хүний нэрийг цагаан толгойн үсгийн дарааллаар нэгтгэн бичсэн нь хожим гарсан олон сонины хувьд дагаж мөрдөх жишиг, аль ч үеийн судлаачдад хэрэг болох мэдээллийн чухал эх сурвалж болсон байна.

“Ардчилал” сонины хоёр дахь дугаар эхнийхтэйгээ нэгэн адил цөөн тооны том бичвэрээс бүрдсэн, анхаарал татахуйц задгай макеттай байв. 1990.04.10-20 гэсэн огноотой энэ дугаар үндсэндээ 4 дүгээр сарын 8-9-нд Улаанбаатарт болж өнгөрсөн Монголын ардчилсан намын анхдугаар их хуралд зориулагдсан гэмээр бөгөөд тус их хурлаас ард түмэнд хандан гаргасан уриалга, Э.Бат-Үүлийн тавьсан улс төрийн илтгэлийг “Бидний үзэл баримтлал — Хүнийг дээдлэн үзэх” гарчгийн дор, С.Зоригийн тавьсан “Эрх баригч МАХН, төрийн эдийн засаг-нийгмийн бодлогын асуудал” хавсралт илтгэлийг “...Үргэлжид сэтгэн бодож яваасай” гарчгийн дор тус тус бүрэн эхээр нь нийтэлжээ. Мөн МоАН-ын анхдугаар их хурлаас БНМАУ-ын АИХ-д өргөн барьсан бичиг, МоАН, МоАХ-ны 1990 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хамтарсан мэдэгдлийг нийтэлсэн байна.

Ийм албан мэдээллээс гадна олон нийтийн санаа бодлыг чөлөөтэй илэрхийлэгч индэр байх зорилтоо хэрэгжүүлэхийн тулд сэтгүүлч Н.Иштавхай, Нанж.Лхагва, Г.Донид нараас хошин шогийн мэргэшсэн цорын ганц хэвлэл “Тоншуул” сэтгүүлийг “Үнэн” сонины хавсарга байгааг болиулахыг хүсч МАХН-ын онц их хуралд илгээсэн боловч хаана ч хэвлэгдэлгүй дарагдсан ил захидлыг нийтэлж, МоАН-ын их хурлын талаар олны танил сэхээтэн, улс төрчдийн хэлсэн санал бодол, шүүмжийг “Сонгох хувилбаруудтай боллоо” гарчгийн дор багцлан

нийтэлжээ. Хилийн чинадад Монголд өрнөсөн ардчиллын үйл явцыг хэрхэн үнэлж байгаа талаарх Английн “Таймс” сонины нийтлэл, “Би-Би-Си”, “Америкийн дуу хоолой”, Канадын олон улсын радио станцийн мэдээллүүдийг МОНЦАМЭ-гийн орчуулгаар ямар нэгэн нэмэлт тайлбаргүйгээр нийтэлсэн нь тухайн үедээ мөн л шинэлэг үзэгдэл байжээ.

Энэ дугаарт нийтлэгдсэн сэтгүүлч Батын Эрдэнэбаатарын “Монголын хавар ирлээ” сурвалжлага бичлэгийн хэлбэр, хийцээрээ анхаарал татаж байна. Тэрбээр 1990 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Сүхбаатарын талбай дээр болсон “Шинэ толь”, “Ардчилал” сонин болон яруу найрагч Р.Чойномын баяраас хийсэн энэхүү сурвалжлагадаа «Монголын анхны чөлөөт хэвлэл “Шинэ толь”, “Ардчилал” сонины баяр болж байна. Даргагүй цуглаан, аппаратгүй эрхлэгч, хянах албагүй сонин гарч байна»<sup>11</sup> гэж бичсэн нь сэтгүүл зүйд урьд өмнө байгаагүй шинэ орчин үүсч буйг баримтжуулан үлдээсэн хэрэг юм.

Тус сонин хоёр дахь дугаараасаа эхлэн “Улаанбаатар. Бага тойруу. “Залуус” танхим” гэж хаягаа, “Д.Сүхбаатарын нэрэмжит Улсын хэвлэлийн комбинатад хэвлэв” гэж хэвлэсэн газраа мэдээлж эхэлсэн ч редакцийн мэдээлэл “Сонины зөвлөл” гэсэн бүрхэг үгээр хязгаарлагдсан хэвээр байжээ.

“Ардчилал” сонины гурав дахь дугаар 1990.04.20-30 гэсэн огноотой

гарчээ. Энэ дугаарын онцлог нь улс төрийн утга агуулга бүхий албан мэдээллээс гадна олон нийтэд зориулсан уншууртай материалын эзлэх жин нэмэгдсэн явдал юм. Түүний нэг нь “Чойномын ээж” гарчиг дор нийтлэгдсэн ярилцлага. Сурвалжлагчийн нэр нь тодорхойгүй энэ ярилцлага яруу найрагч Р.Чойномын хүүхэд нас, аав, анд нөхөд, ээжийнх нь дотоод сэтгэлийн тухай харьцангуй их мэдээлэлтэй, уншихад хөнгөн гүйлгүүр ярилцлага болжээ.

«

*“Ардчилал” сонины анхны дугаарын загвар дэглэлтийг Ш.Мягмарсамбуу шинэлэг байдлаар хийж, тухайн үедээ манай сэтгүүл зүйд төдийлөн нэвтрээгүй байсан задгай макет ашиглаж, “Шинэ цаг ирлээ, сэргээе!” гэсэн гарчгийг томоор өгсөн нь дизайны зоримог шийдэл, шинэ өнгө төрх болж чаджээ*

»

Тухайн үеийн бичлэгийн онцлогоо дагаад асууж хариулсан хөөрөлдөөн дундуур үе үе сэтгүүлчийн бодол дүгнэлт, ярилцлагын баатраа тодотгосон зураглал шигтгэсэн нь анхаарал татна.

“Ардчилал” сонин өөрийн сэтгүүлчдээ анхаарал татсан онцгой цэг рүү тусгай томилолтоор явуулж эхэлсэн нь энэ дугаараас тодорхой байна. Сэтгүүлч Батын Эрдэнэбаатар Баян-Өлгий аймаг руу томиллолтоор явж, тухайн үедээ дуулиан шуугианы гол төв болоод байсан Асгатын мөнгөний ордын талаар сурвалжилснаа “Асгатын мөнгө” гэсэн гарчигтайгаар нийтэлжээ. Тус ордод явуулж буй хайгуул судалгааны ажилтай газар дээр нь танилцаж, Орос-Монголын эдийн засгийн харилцаа тэгш шударга байгаа эсэх, экологи, нутгийн уугуул иргэдийн гээд асар олон асуудлыг хөндөж чадсан энэ нийтлэлийн ач холбогдол хорин хэдэн жилийн дараа улам бүр тодорч байгаа нь “Ардчилал” сонин

тухайн үедээ гол чухал асуудлыг далайцтай хөндөж байсныг харуулж байна.

Ардчиллын сүлд дуу болсон “Хонхны дуу”-г зохиогч, сэтгүүлч С.Цогтсайханы “Би яагаад Монголын ардчилсан холбоонд элссэн бэ?” нийтлэл энэ дугаарт гарчээ. Ардчиллын үзэл санааг дэмжигч сэтгүүлчдийн том төлөөлөгч С.Цогтсайханы уран бүтээлийн нэг шинэ үе буюу “Ардчилал” сонинд ажиллаж, бичиж эхэлсэн үе эндээс эхэлж байгаа юм.

“Ардчилал” сонины түүхтэй холбоотойгоор зайлшгүй дурдах ёстой нэг баримт бол Эрдэнэтэд хэвлэгдээд улс төрийн алдаатай гарсан гэх шалтгаанаар устгалд орсон зэрэгцээ дугаарын асуудал юм. Энэ дугаар нь “Сайн үйлс бүхэн дэлгэртүгэй” гэсэн уриатай, “Монголын ардчилсан намын анхдугаар их хуралд зориулав” гэж толгой, урианыхаа дээгүүр томоор бичсэн, цагаан сүүдэртэй хар өнгийн “А” үсгэн дээр галын дөл зурсан логотой, “Ардчилал” хэмээх нэрийнхээ бүх үсгийг жижиг үсгээр бичсэн, толгойныхоо доогуур “№ 000001 МоАХ, Монголын ардчилсан нам. Үнэ 2 төгрөг” гэж бичсэн АЗ-ын хэмжээтэй 4 нүүр сонин байжээ. Нэгдүгээр нүүрийн дээд хэсэгт хөндлөнгөөр “Үнэн” сонины 1990 оны №60-аас авсан “Ард түмний сонорт хүргэх улс төрийн тунхаглал”-ыг нийтэлж, 1990.III.14 гэсэн огноотой “Шинэ сэтгэлгээгээр хандъя” гарчигтай мэдэгдлийг доогуур нь байрлуулжээ. Сонины хоёрдугаар нүүрт Г.Бошигтын “Шинэ маягийн намын тухай”, Ц.Элбэгдоржийн “Үнэний мөр цагаан” өгүүллүүд хэвлэгдсэн байна. Г.Бошигт шинэ, хуучин намуудын ялгаа, ардчилал гэж юу болох, нам ба ард түмний эрх, онцлогийн талаар ухуулан өгүүлсэн бол Ц.Элбэгдорж шинэ тулгар

ардчилсан хөдөлгөөний эсрэг эрх баригч МАХН ямар бодлого барьж байгааг шүүмжлэн илчлээд нэг намын ноёрхол өндөрлөж байгаа, цагаан морин жилийн өдөр бүхэн түүхэнд орж буйг тэмдэглээд “Цаг үе бүхнийг өөрчлөх жамтай ч цаг үеийг түр эзэгнэн саатуулагч хүчин байдаг ажээ” хэмээн ардчиллын үйл хэрэгт зүйл бүрээр хориг тавихыг оролдож буй хуучинсаг хүчнийхнийг дүгнэсэн байна. Сонины гуравдугаар нүүр тэр чигээрээ МОАХ-ны Хөтөл дэх салбар зөвлөлийн бэлдсэн материалаас бүрдсэн бол арын нүүрэнд Баянхонгор аймгийн Баянбулаг сумын хэсэг иргэдээс МоАХ-ыг дэмжиж илгээсэн захидал, эгэл монгол хүн нэгэн үе ширээний ардлаглайн суусан даргыг нуруун дээрээ үүрч ирэв гэсэн утга бүхий шог зураг нийтлэгджээ.

Сонины арын нүүрний доод хэсэгт “Улаанбаатар. Бага тойрог. МоАХ” гэсэн хаяг, дансны дугаараа нийтэлсэн байна. Энэ дугаарын арын нүүрэнд “Сураг алдарсан захидал” гарчгийн дор нэгэн захидлын хэсгээс нийтэлсэн нь сонирхол татаж байна. Хэн бичсэн нь тодорхойгүй энэ захидлын өмнөх тодотгол үгэнд “1988 оны намар Зөвлөлтийн нэрт зохиолч, байгаль хамгаалах асуудлаар цогтой нийтлэлүүд бичиж, түүнийгээ ажил болгохын төлөө тууштай тэмцэгч В.Г.Распутинд захидал бичсэн авчиг илгээх зориг зүрх дутаж хэдэн сар болгоод МАХН-ын ТХ-ны V бүгд хурлын дараа буюу 1989 оны 1-р сард баталгаат захианы ёс журмын дагуу Эрхүү рүү явуулсан юм. Гэтэл уг захиа хаягласан хүндээ очоогүй байлаа”<sup>12</sup> гэж учирлаад уг захидлыг холбооныхон үрэгдүүлсэн, аюулаас хамгаалахынхан саатуулсан алин болохыг хэлж мэдэхгүй ч хувийн

шугамаар захидлынхаа нэг хувийг ямартаа ч 1989 оны 10 дугаар сард хүргүүлсэн, нэрт зохиолч хариу заавал бичнэ гэж амласан ч зав нь болоогүй юу, эсвэл бас хөндлөнгийн шүүлтүүрт орсон уу, ямартаа ч амласан хариу нь ирээгүй гэсэн байна. Уг захидал Зөвлөлтийн мэргэжилтнүүд Монголын аль сайхан гэсэн байгалийг хайр найргүй сүйтгэн бохирдуулж, хэмжээлшгүй хохирол учруулж байгаа ч энэ нь бичиж нийтлүүлж болохгүй хаалттай сэдвийн нэг хэвээр байгааг учирласнаар эхэлсэн байх бөгөөд сонины зай талбайн боломжоос болоод багахан хэсгийн оруулаад “Үргэлжлэл нь дараагийн дугаарт” хэмээн төгсгөжээ. Энэ захидлын эзэд нь 1988 оноос хойш “Сэтгүүлч” сэтгүүл, “Хөдөлмөр” сонин зэрэгт хэлмэгдэгсэдтэй хийсэн цуврал ярилцлагуудаа нийтлүүлж олонд ихээхэн алдаршиж байсан Нанж.Лхагва, Г.Донид нарынх болох нь мөнөөх захидалд “Монголын жирийн сэхээтэн бид хоёр Зөвлөлтийн болон дэлхийн утга зохиолыг уншдаг, мөн заримаас нь орчуулдгийн хувьд таны уран зохиол болон нийтлэлийг талархан уншигчид билээ” гэж В.Г.Распутинд өөрсдийгөө танилцуулснаас, мөн Нанж.Лхагва өөрөө «Бид хоёрын Распутинд бичсэн захидал “Ардчилал”-ын анхны дугаарт гарсан» (Нанж.Лхагвагийн дурсамж, «Донид бид хоёрын “Распутинд бичсэн захидал” нэртэй нийтлэл гарсан»<sup>3</sup> гэж ярьснаар батлагдаж байна. Тэгэхдээ Нанж.Лхагва 2012 онд “Ардчилал” сонинд ярилцлага өгөхдөө “Сураг алдарсан захидал” гэсэн гарчгийг “Распутинд бичсэн захидал” гэж андуурч хэлсэн нь тодорхой.

“Ардчилал” сонины энэхүү устгагдсан дугаар загвар дэглэлтийн хувьд ядмагхан, шрифтийн сонголт тааруу,

шугам, тусгаарлах элементийг болхи хэрэглэсэн, техникийн талаас гүйцэтгэл муутай, хэвлэлтийн чанар ч сайнгүй байгаа нь орон нутгийн хэвлэх үйлдвэрт хэвлэсний нотолгоо гэж үзэж болмоор юм.

Энэ дугаарыг хаана хэдэн хувь хэвлэсэн, дугаар гаргахад оролцсон хүмүүс, эрхлэн гаргагчдын нэр, тэр бүү хэл яг хэдэн сарын хэдний өдөр хэвлэгдэн гарсан нь ч уг сониныг харахад тодорхой бус байна. Гэхдээ ардчилсан хөдөлгөөний удирдагч С.Зориг нэгэн зэрэг хэд хэдэн хувилбараар сонин бэлдүүлж байсан тухай Ш.Мягмарсамбуугийн дурсамж яриа, “Анхны дугаар Эрдэнэтэд гарсан юм”<sup>14</sup> гэж Нанж.Лхагва ярилцлага өгөхдөө хэлсэн зэрэг олон баримтаар энэ дугаар Эрдэнэтэд хэвлэгдсэн болох нь батлагдаж байна.

**И**нгэж олон хувилбараар хэвлэгдэж байснаас гадна “Ардчилал” сонины редакци нь хуваагдах, ижил төстэй нэрээр өөр өөр редакци эрхлэн гаргах зэргээр ихээхэн хөдөлгөөнтэй байсан нь хожмын судлаачдыг төөрөгдөлд оруулж болзошгүй тул амьд гэрч, бодит баримт байгаа дээр нь “Ардчилал” сонины түүхийг нарийвчлан тодотгох нь чухал байна. Зөвхөн “Ардчилал” сонины эрхлэгчээр ажилласан хүмүүс гэхэд л С.Амарсанаа, Ш.Мягмарсамбуу, Нанж.Лхагва, Б.Эрдэнэбаатар, С.Адияахүү, Дарь.Сүхбаатар гээд нэлээд олон хүн байна.

“Ардчилал” сонин 1991 оны 1 дүгээр сарын 31-нд анхны хавсралтаа мөн л “Ардчилал” нэрээр гарган 2 төгрөгөөр худалдаалжээ. Энэ хавсралт нь материалын уншуурт нэлээд анхаарсан шинжтэй бөгөөд тэргүүн нүүрт нь гэхэд л Торао Мозаигийн “Хубилай хааны сүйдсэн флот”, “Монголын усан

цэргийн жанжин Алахаан: Гавьяа бүтээж эс чадваас хадага төмрийг огтолсугай” гэсэн томоохон материалууд, арын дөрөвдүгээр нүүрт орчуулагч Ч.Куландагийн япон хэлнээс буулгасан “Гадаад Монголын оргодол ахмад Бямбаагийн тэмдэглэл”-ийг тус тус нийтэлжээ.

“Ардчилал” сонин энэхүү хавсралтаа 3 дугаар гаргаж үзээд шинэ сонин эрхлэн гаргаж болох юм гэсэн шийдэлд хүрсэн тул “Сайн байна уу?” сониныг эрхлэн гаргахаар болжээ. «Гэрчилгээ №133. Үүсгэн байгуулагч “Ардчилал” сонины газрын өргөдлийг хянан хэлэлцээд “Сайн байна уу” сонинг улсын бүртгэлд бүртгэж, БНМАУ-ын нутаг дэвсгэрт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрч гэрчилгээ олгов. БНМАУ-ын Хууль зүйн яам. 1991 оны 12-р сарын 12 өдөр» гэсэн албан ёсны гэрчилгээ авсны үндсэн дээр 1992 оны 3 дугаар сард анхны дугаараа гаргажээ.

**Э**нд хэд хэдэн сонин зүйл анзаарагдаж байна. “Сайн байна уу?” сонины тэргүүнд “Ардчилал” сониноос эрхлэн гаргав” гэсэн мэдээллийг байршуулахдаа “Ардчилал” гэдэг үгийн оронд “Ардчилал” сонины МоАХ-ны лого бүхий толгойг тэр хэвээр нь жижиглэн оруулжээ. Тэгэхдээ бие даасан сонин байлгахаар анхнаасаа бодолцсон нь тус сонины эрхлэгч Ш.Мягмарсамбуу “Сайн байна уу? Та” гарчигтай мэндийн үгэндээ «Ардчиллын ачаар Монголд биеэ даасан, аль нэг байгууллагын бөөрөнд аваачиж наагаагүй хэвлэл бий болох зам нээгдэв. Урьд манайх нийт үндэстний биеэ даасан, өдөр тутмын сонинтой байсангүй. Одоо ч алга. Тиймээс “Ардчилал” сонины хамт олон ийм нэгэн сонины эх үүсвэрийг тавих эрмэлзэл өвөрлөн “Сайн байна уу?”

сониныг та бүхэндээ толилуулж байна»<sup>15</sup> гэснээс тодорхой байна. Өөрөөр хэлбэл үндэсний хэмжээний өдөр тутмын чөлөөт сонин бий болгох санаачилгыг “Ардчилал” сониныхон анх гаргаж, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд “Сайн байна уу” сониныг гаргажээ хэмээн дүгнэж болно.

Хоёр дахь онцлог нь энэ бол хавсралт сонин биш, бие даасан сонин бөгөөд “Ардчилал” сонин энд зөвхөн үүсгэн байгуулагч субъект л юм гэдэг нь эрхлэгчийнх нь анхны дугаартаа бичсэн мэндийн үгнээс ч, Хууль зүйн яамнаас олгосон гэрчилгээн дээрх “Сайн байна уу?” сониныг улсын бүртгэлд бүртгэж” гэсэн үгнээс ч тодорхой байна.

“Сайн байна уу?” сонин анхны дугаартаа “Энэхүү сониныг “Ардчилал” сонины III сарын 1-15-ны дугаар 9-10-ын оронд уншигч, захиалагч нартаа хүргэж буйг болгооно уу” гэж зарлан мэдээлснээс үзвэл “Ардчилал” сонины тасарсан дугаарын оронд нөхөөс болгон захиалагчдад хүргэсэн болж таарч байна.

“Ардчилал” сонин хэсэг хугацаанд “Ардчилал times” нэрээр гарсан түүх бас байна. “Ардчилал times” сониныг С.Зориг, Нанж.Лхагва, Ш.Мягмарсамбуу нар хувийн хэвшлийн нийгэм, улс төрийн чиглэлтэйгээр сард 2 удаа А-2 хэмжээтэй 8 нүүрээр хэвлэгдэнэ гэж ХЗЯ-нд 1993 оны 8 дугаар сарын 9-нд бүртгүүлсэн байна. “Ардчилал times” сонины анхны дугаарт “Эрхлэн гаргагчид: Нанжаагийн Лхагва, Чонайн Куланда, Санжаасүрэнгийн Зориг, Шавьхүүгийн Мягмарсамбуу” гэж зарлан мэдээлсэн байх бөгөөд ерөнхий эрхлэгч Нанжаагийн Лхагва ийм сонин гаргасны учрыг тайлбарласан эрхлэгчийн зурвастаа «Дөрвөн хүний үүсгэн санаачилсан энэ сонин бол хувийнх



байх болно... “Ардчилал Таймс” буюу (Ардчилал-Цаг үе) сонин ямар ч нам, эвсэл, байгууллагын мэдэлд орохгүй чөлөөт хэвлэл байж эх орныхоо, монголчуудынхаа сайн сайхны төлөө нийтлэлээ зориулах тууштай бодлого баримталж, гол гол нийтлэлээ ажил болгохыг хичээх болно»<sup>16</sup> гэсэн, Хууль зүйн яаманд бүртгүүлэхдээ “хувийн хэвшлийн нийгэм, улс төрийн сонин”<sup>17</sup> гэж бүртгүүлснээс харахад “Ардчилал Таймс” нь МоАХ-ны хэвлэл биш байна. Нэлээд хурц дайчин нийтлэлтэй энэ сонин дугаарын гаралтын хугацаа нь тогтмол биш явсаар 1999 оны эхээр нэрээ “The problems” болгож, улмаар сураг алдарсан байна.

« Ардчилал Таймс»-аас найман сар орчмын дараа Батын Эрдэнэбаатар 1994 оны 4 дүгээр сарын 13-нд ХЗЯ-нд “Ардчилал-266” сониныг сард 2 удаа А-2 хэмжээтэй 8 нүүрээр хэвлэгдэх хувийн сонин гэж бүртгүүлжээ.

МоАХ-ны дэргэд байсан “Ардчилал” сонин ийнхүү гурван ч сонин болон аль аль нь алдаг оног гарч, хэсэг зуур үйл ажиллагаа нь тасалдаж байснаа 1997 оноос хойш өдөр тутмын сонин болсон байна. “Ардчилал” сониныг 2009 оны 9 дүгээр сарын 24-нд Халтмаагийн Баттулга “Нийтэд зориулсан танин мэдэхүй, амралт, чөлөөт цагт зориулсан мэдээ мэдээлэл хүргэх”<sup>18</sup> зорилготой хэвлэл хэмээн Хууль зүйн яаманд шинэчлэн бүртгүүлсэн байна.

“Ардчилал” сонин бол итгэл үнэмшлээрээ эвлэлдэн нэгдсэн хүмүүс, хувь хүн ч гэсэн тогтмол хэвлэл эрхлэн гаргаж болох юм байна гэдэг санаа сэдэл, эр зоригийг нийгэмд өгч, 1990-ээд оны сонин шинэ давалгаа эхлэхэд хамгийн их нөлөөлсөн хэвлэл мөн.

## Ишлэл

<sup>1</sup> Амарсанаа С. 2011. Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд. УБ., 98 дахь тал.

<sup>2</sup> Дарь. Сүхбаатарын цахим захидал (Б.Галааридын хувийн архив).

<sup>3</sup> Амарсанаа С. Дурд. зох., 169-170 дахь тал.

<sup>4</sup> Баасансүрэн Т. 2009. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэг төлөвшсөн нь. Гутгаар дэвтэр. УБ., 37 дахь тал.

<sup>5</sup> Ш. Мягмарсамбуугийн дурсамж (Б.Галааридын хувийн архив).

<sup>6</sup> Оюунчимэг Т. 2011. Миний хүссэн ардчилал биш. УБ., 21 дэх тал.

<sup>7</sup> Амарсанаа С. Дурд. зох., 212 дахь тал.

<sup>8</sup> Баасансүрэн Т. 2009. 1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв. УБ.

<sup>9</sup> Амарсанаа С. Дурд. зох., 207 дахь тал.

<sup>10</sup> З. Эрдэнэбатын захидал (Б.Галааридын хувийн архив).

<sup>11</sup> Эрдэнэбаатар С. “Монголын хавар ирлээ” сурвалжлага // “Ардчилал” сонин. 1990.04.10-20, №2.

<sup>12</sup> “Ардчилал” сонин. 1990, №01.

<sup>13</sup> Нанж. Лхагва: «“Ардчилал” сонин монголчуудын нүдийг нээж өгсөн» ярилцлага // “Ардчилал” сонин, 2012.04.09, №071, 072.

<sup>14</sup> Мөн тэнд.

<sup>15</sup> “Сайн байна уу? Та” эрхлэгчийн зурвас // “Сайн байна уу” сонин. №1. 1992 оны 3-р сар.

<sup>16</sup> Нанж. Лхагва. “Ардчилал-Таймс мэндэлсний учир” // “Ардчилал Таймс” сонин. 1993, №01.

<sup>17</sup> Хууль зүйн яаманд бүртгэлтэй хэвлэл мэдээллийн хэрэгслийн судалгаа (Гар бичмэл эх. О.Содномпиллийн хувийн архив).

<sup>18</sup> Содномпил О., Одхүү С. 2013. Монголын сонин шинэ давалгаан. УБ., 300 дахь тал.

## Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Амарсанаа С. 2011. Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд. УБ.

2. Баасансүрэн Т. 2009. 1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв. УБ.

3. *Баасансүрэн Т.* 2009. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэг төлөвшсөн нь. Гутгаар дэвтэр. УБ.

4. Дарь. Сүхбаатарын цахим захидал (Б.Галааридын хувийн архив).

5. З. Эрдэнэбатын захидал (Б.Галааридын хувийн архив).

6. *Нанж. Лхагва.* “Ардчилал-Таймс мэндэлсний учир” // “Ардчилал Таймс” сонин. 1993, №01.

7. *Нанж. Лхагва:* «“Ардчилал” сонин монголчуудын нүдийг нээж өгсөн» ярилцлага // “Ардчилал” сонин, 2012.04.09, №071, 072.

8. *Норовсүрэн Л.* 2000, 2001, 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ., 1-3-р дэвтэр.

9. *Оюунчимэг Т.* 2011. Миний хүссэн ардчилал биш. УБ.

10. “Сайн байна уу? Та” эрхлэгчийн зурвас // “Сайн байна уу” сонин. №1. 1992 оны 3-р сар.

11. *Содномпил О., Одхүү С.* 2013. Монголын сонинны шинэ давалгаан. УБ.

12. Хууль зүйн яаманд бүртгэлтэй хэвлэл мэдээллийн хэрэгслийн судалгаа (Гар бичмэл эх. О.Содномпилийн хувийн архив).

13. Ш. Мягмарсамбуугийн дурсамж (Б.Галааридын хувийн архив).

14. *Эрдэнэбаатар С.* “Монголын хавар ирлээ” сурвалжлага // “Ардчилал” сонин. 1990.04.10-20, №2.

### Резюме

В настоящей статье автор затрагивает аспекты возникновения и развития независимой прессы в Монголии в конце 80-х— начале 90-х гг. При этом автор опирается на воспоминания главных действующих лиц того времени и на материалы из личного архива. Им выдвигается версия о том, что газета “Ардчилал” (“Демократия”), первый номер которой вышел 7 апреля 1990 г., является главной печатью, которая внесла самый весомый вклад в развитие независимой монгольской прессы.